

## СЗХ - Ашид Капитал (Simple) ББСБ-ын БЖДБ Зээл

Орон:	МОНГОЛ УЛС
Төслийн дугаар:	53905
Бизнесийн салбар:	Банк санхүү (банк бус)
Мэдэгдлийн төрөл:	Хувийн
Байгаль орчны ангилал:	Санхүүгийн зуучлал (FI)
Төсөл батлах төлөвлөгөөт огноо:	2025 оны 8 дугаар сарын 5
Төлөв байдал:	Баталсан
Төслийн хураангуйг Англи хэл дээр танилцуулсан огноо:	2025 оны 8 дугаар сарын 7

### Төслийн танилцуулга

Монголын тэргүүлэгч бичил санхүүгийн байгууллагуудын нэг болох, ЕСБХБанкны шинэ харилцагч Ашид Капитал ББСБ ХХК-д ("Simple" эсвэл "Компани") 2 сая евро хүртэлх (төгрөгтэй тэнцэх) анхдагч өглөгт тооцогдох, барьцаагүй зээл олгох төсөл. Санхүүгийн Зуучлагч Байгууллагууд хөтөлбөр ("СЗБ")-ийн хүрээнд хоёр тэнцүү хуваан олгох бөгөөд хоёр дахь траншийн нөхцөлийг олгох үед тохирно.

### Төслийн зорилго

СЗБ-ийн зорилготой нийцүүлэн, энэхүү төсөл нь Simple-д дунд хугацааны, дотоодын валютын санхүүжилт олгох бөгөөд энэ нь Монгол улсын хувийн БЖДБ-уудад зээлдүүлэхэд зориулагдсан ба Санхүүгийн Салбарын Стратеги болон Монгол Улсад Баримтлах Стратегид онцолсон санхүүжилтийн хомсдлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах юм. Тус төсөл нь дотоодын БЖДБ-уудад олгох санхүүжилтийг нэмэгдүүлэх, Simple-н хариуцлагатай зээл олголтыг дэмжин зээлийн чанарыг хадгалах, мөн Монгол Улсын хамгийн том конгломерат болох MCS Групп-тэй харилцаагаа улам бэхжүүлэхэд чиглэж байна. MCS Групп нь ЕСБХБанкны харилцагч бөгөөд Simple-ийн толгой компани юм.

### Шилжилтийн нөлөөлөл

Хүлээгдэж буй шилжилтийн нөлөөлөл: 60

Тус БЖДБ-н зээл нь СЗБ -ын зорилгод хувь нэмрээ оруулан, Өрсөлдөх чадвартай болон Тэсвэртэй шилжилтийн чанаруудыг дэмжинэ.

## Харилцагчийн мэдээлэл

АШИД КАПИТАЛ ББСБ ХХК

Ашид Капитал ББСБ ХХК нь “Simple” нэрийн дор үйл ажиллагаагаа явуулдаг хувийн бичил санхүүгийн байгууллага юм. 2020 онд байгуулагдсан тус компани нь 2024 оны жилийн эцсийн байдлаар 88.1 сая ам.долларын зээлийн багц, 100.6 сая ам.долларын нийт актив, 24.8 сая ам.долларын өөрийн хөрөнгөтэй, Монгол улсын ББСБ-ын зах зээлийн 6%-ийг эзэлж, гурав дахь том ББСБ болсон. Тус Компаний төв нь Улаанбаатар хотод байрладаг бөгөөд 6 салбар, 107 ажилтантай.

## ЕСБХБ-ны санхүүжилтийн товч мэдээлэл

2,000,000.00 евро

2,000,000.00 евро хүртэлх анхдагч өглөгт тооцогдох, барьцаагүй зээл (төгрөгөөр)

## Төслийн нийт өртөг

2,000,000.00 евро

## Нэмэлт нөлөө

*Санхүүжилтийн бүтэц:* ЕСБХБ нь зах зээл дээр өргөнөөр олддоггүй нөхцлөөр дунд хугацааны, дотоодын валютын санхүүжилт олгодог.

*Стандарт тогтоох:* Дэд зээлдэгчдэд тавигдах тодорхой шалгуур, ЕСБХБ-ны байгаль орчин, нийгмийн стандартыг даган мөрдөх, гэрээ болон тайлангийн шаардлагуудыг хангах, мөн одоогийн зах зээлийн жишгээс өндөр шаардлага бүхий стандартуудыг хэрэгжүүлэх зэрэг нь дотоод санхүүгийн салбарын өрсөлдөх чадвар болон тэсвэртэй байдлыг сайжруулахад чухал үүрэгтэй.

*Жендэрийн мэдрэмжтэй:* Компани “We-Finance Code”-д нэгдэж сургалт семинарт хамрагдсанаар эмэгтэйчүүд эзэмшдэг/удирддаг БЖДБ-уудад үйлчилгээ үзүүлэх чадвараа нэмэгдүүлэх хүлээлттэй байна. Энэ санаачилга нь зохицуулагч байгууллагууд болон санхүүгийн байгууллагуудыг нэгтгэн, эмэгтэй бизнес эрхлэгчдийн санхүүжилтын хэрэгцээг хамтран, зохион байгуулалттайгаар шийдвэрлэхийг зорьдог.

*Мэдлэг ба инноваци:* ЕСБХБ нь арилжааны хөрөнгө оруулагчдад байдаггүй БЖДБ -ын зээл олгох туршлага, мэдлэгийг санал болгодог. Мөн ЕСБХБ-ийн Жижиг Дунд Бизнесийн Бүс Нутгийн Хөтөлбөр (RSBP) хэмээх цахим мэдлэг хуваалцах платформыг ашиглах боломжийг Simple-д үүсгэснээр тэд зээлийн үнэлгээ, эрсдэлийн удирдлага, ажилтнуудын ур чадвараа сайжруулахад тусална. Мөн зөвхөн ЕСБХБ л RSBP- хамрагдах, дотоод валютаархсанхүүжилт олгох бүхий багц санал болгодог. Энэ нь санхүүгийн зуучлагч байгууллагуудад, түүний дотор тус Компанид, шилдэг туршлагыг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох юм.

## Байгаль орчин, нийгмийн үйл ажиллагааны хураангуй

(ESP 2019)-ийн дагуу Санхүүгийн байгууллага (FI) ангилалд хамаарагдсан. Ашид Капитал нь бичил санхүүгийн байгууллага бөгөөд ЕСБХБ-ны шинэ харилцагч юм. Шаардлага хангасан дэд төслүүд нь ЖДБ-уудын санхүүжилтийг дэмжих бөгөөд байгаль орчин, нийгмийн (E&S) эрсдэл нь багаас дунд түвшний байх төлөвтэй. Үндсэн E&S эрсдэл нь Компанийн Байгаль орчин, нийгмийн удирдлагын тогтолцоог (ESMS) хэрэгжүүлэх чадавхи, хөдөлмөрийн болон ажлын байрны аюулгүй байдал (OHS)-ын асуудлууд, мөн төслөөс үүдэх боломжит байгаль орчин, нийгмийн нөлөөллүүдтэй холбоотой байна. E&S-н нарийвчилсан шинжилгээг Компанийн бөглөсөн E&S асуулгын хуудасны үнэлгээ, дараагийн шатны харилцаа холбоо, цахим уулзалт, нэмэлт баримт бичгүүдийг шалгах замаар хийгдсэн. Ашид Капитал нь Хүний нөөцийн бодлоготой, мөн ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын журам тодорхой хэмжээнд боловсруулагдсан хэдий ч, бүрэн хөгжүүлсэн ESMS одоогоор байхгүй байна.

Байгаль орчин, нийгмийн шалгалтаар, ялангуяа Гүйцэтгэлийн Шаардлага (PR) 9 болон бага хэмжээнд PR 2, PR 4-тэй холбоотойгоор нийцлийн зарим дутагдлууд илэрсэн. Эдгээр дутагдлууд Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөө (ESMP)-д тусгасан тодорхой арга хэмжээгээр шийдвэрлэгдэх бөгөөд уг төлөвлөгөө нь санхүүжилтийн гэрээнд тусгагдсан байх болно.

Харилцагч нь шаардлагатай тохиолдолд Байгаль орчин, нийгмийн менежментийн тогтолцоогоо (ESMS) хөгжүүлж, 2019 оны Байгаль орчин, нийгмийн бодлогын (ESP) хүрээнд Гүйцэтгэлийн Шаардлага (PR) 2, 4, 9-т нийцүүлэн байгаль орчин, нийгмийн эрсдэл, нөлөөллийг үр дүнтэй үнэлэх, удирдах, хянах боломжийг бүрдүүлэх ёстой. Үүнд ЕСБХБ-ын байгаль орчин, нийгмийн хориотой үйл ажиллагааны жагсаалт, мөн лавлагааны жагсаалтыг дагаж мөрдөх, санхүүгийн байгууллагуудад зориулсан холбогдох заавар, зөвлөмжтэй нийцүүлэх зэрэг багтана. Харилцагчийн санхүүжүүлж буй дэд зээлдэгчид нь үндэсний байгаль орчин, хөдөлмөр, эрүүл мэнд, аюулгүй байдлын холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх шаардлагатай. Ашид Капитал нь жил бүр ЕСБХБ-д E&S тайлан ирүүлж байх бөгөөд уг тайланд ESMS хэрэгжилтийн явц, ЕСБХБ-ны шаардлагуудын хэрэгжилт, дэд төслүүдийн үнэлгээний дүн, E&S зөрчилтэй холбоотой тайлан тусгасан байна.

Төслийг ЕСБХБ-ын шууд бус санхүүжилтийн хөрөнгө оруулалтад зориулсан Парисын хэлэлцээртэй нийцүүлэх аргачлалыг ашигласны үндсэн дээр Парисын хэлэлцээртэй нийцэж байна гэж үзсэн. Нийцлийн үнэлгээг 1-р тулгуур (харилцагч талын Парисын хэлэлцээрт нийцүүлэх амлалт) ба 2-р тулгуур (дэд хэлцлүүдийн шүүлтүүр)-ын хэрэгжилтэд үндэслэнэ.

## Техникийн туслалцаа ба буцалтгүй тусламжийн санхүүжилт

**А. Техникийн туслалцаа (TC):** Байхгүй.

**В. Хамтран хөрөнгө оруулах буцалтгүй тусламж / Хөнгөлөлттэй санхүүжилт ("Non-TC"):** 12.5%-ийн анхдагч алдагдлын баталгааг ЕСБХБ-нд ЖДҮ-ийн дотоод валютын тусгай сангаас гаргана олгоно.

## Компаний холбоо барих хүний мэдээлэл

Анужин Очирбат

[anujin.o@simple.mn](mailto:anujin.o@simple.mn)

+976 8008 9009

simple.mn

Сентрал тауэр, 5-р давхарт, Сүхбаатарын талбай 2, СБД-8, Улаанбаатар 14200, Монгол

## Шилжилтийг ойлгох нь

Шилжилтийн нөлөөллийг хэмжих чиглэлд ЕСБХБ-ны баримталдаг арга хандлагын талаарх нэмэлт мэдээллийг [эндээс](#) авна уу.

## Бизнес боломжууд

Бизнес боломжууд болон худалдан авалтын талаар үйлчлүүлэгч компанитай холбогдоно уу.

ЕСБХБ-тай хамтран ажиллах боломжууд (худалдан авалттай холбоогүй)-ын талаар сонирхвол дараах утасны дугаар, цахим хаягаар холбоо барина уу.

Утас: +44 20 7338 7168

Цахим шуудан: [projectenquiries@ebrd.com](mailto:projectenquiries@ebrd.com)

Төрийн хэвшлийн төслүүдтэй холбоотой мэдээлэл авахыг хүсвэл [ЕСБХБ-ны Худалдан авалт](#) хэсэгт зочилно уу.

Утас: +44 20 7338 6794

Цахим шуудан: [procurement@ebrd.com](mailto:procurement@ebrd.com)

## Ерөнхий лавлагаа

Дэлгэрэнгүй лавлагааг [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан авах боломжтой.

## Байгаль орчин, нийгмийн бодлого (БОНБ)

[БОНБ](#) болон холбогдох Гүйцэтгэлийн Шаардлагууд (ГШ) нь ЕСБХБ-ны “байгаль орчинд ээлтэй, тогтвортой хөгжил”-ийг хөхиүлэн дэмжих үүрэг амлалтаа биелүүлэхэд баримтлах арга замуудыг тодорхойлдог. БОНБ болон ГШ-д үйлчлүүлэгчийн зүгээс олон нийтийн мэдээлэл, хэлэлцүүлгийн талаарх үндэсний хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг дагаж мөрдөх, мөн оролцогч талуудын санал гомдол, ялангуяа үйлчлүүлэгч ба төслийн байгаль орчны болон нийгмийн гүйцэтгэлийн талаарх санал гомдлыг хүлээн авч, шийдвэрлэдэг гомдол барагдуулах механизм бий болгох тухай тодорхой заалтууд багтсан байдаг. ЕСБХБ нь аливаа төслийн байгаль орчны болон нийгмийн эрсдэл, нөлөөллийн мөн чанар, цар хүрээнд дүйцүүлэн, тухайн төслийн улмаас үүсэх эрсдэл, үр нөлөөллийн тухай мэдээллийг шаардлагын дагуу ил болгох, эсвэл оролцогч

талуудтай утга учиртай зөвлөлдөх, тэдний санал хүсэлтийг харгалзан үзэж, хариу өгөх нэмэлт шаардлагыг үйлчлүүлэгчиддээ тавьдаг.

Энэ чиглэлд ЕСБХБ-ны хэрэгжүүлдэг практикийн талаарх нэмэлт мэдээллийг [БОНБ](#)-д оруулсан болно.

## Бүрэн төгс байдал ба комплаенс

ЕСБХБ-ны Комплаенс хариуцсан Захирлын Ажлын алба (КЗАА) нь сайн засаглалыг хөхиүлэн дэмжиж, олон улсын шилдэг практикт нийцүүлэн Банкны бүхий л үйл ажиллагаан дахь бүрэн төгс байдлыг хамгийн дээд стандартаар хангахад анхаарч ажилладаг. Төслүүдийн зүгээс Банкинд бүрэн төгс байдал, нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөх боломжгүй эрсдэл үүсгэхгүй байх нөхцлийг хангахын тулд тус Банк бүх үйлчлүүлэгчийнхээ бүрэн төгс байдалд нарийвчилсан үнэлгээ хийдэг. Банк аливаа асуудлыг төслийн үнэлгээг батлах үе шатанд илрүүлэн тогтоож, шийдвэрлэх нь Банкны транзакцийн бүрэн төгс байдлыг хангах хамгийн үр дүнтэй арга зам гэж үзэж байна. КЗАА нь эдгээр хамгаалалтын арга хэмжээг авахад голлох үүрэг гүйцэтгэж, мөн төслүүдийн хөрөнгө оруулалтын дараах бүрэн төгс байдлын эрсдлийг хянахад тус дөхөм үзүүлдэг.

Түүнчлэн, КЗАА нь ЕСБХБ-ны санхүүжүүлсэн төслүүдтэй холбоотой залилан мэхлэлт, авилга, хээл хахууль болон буруу үйлдлийн талаарх гомдлын мөрөөр судлан шалгах үүрэгтэй. Банкны ажилтнууд, эсвэл гадна байгаа хэн ч бай залилан мэхлэлт болон авилгал үйлдэгдсэн хэмээн сэжиглэж буй тохиолдолд Комплаенс хариуцсан захиралд [compliance@ebrd.com](mailto:compliance@ebrd.com) цахим шуудангийн хаяг руу бичгээр илтгэх ёстой. Мэдээлэгдсэн бүхий л асуудлын мөрөөр хянан шийдвэрлэх ажлыг КЗАА гүйцэтгэнэ. Нэр хаягтай болон нэр хаяггүй бүх мэдээллийг шалгана. Мэдээллийг Банкны албан ёсны хэл болон үйл ажиллагаа явуулдаг улс орнуудын хэлний алинаар ч үйлдэж болно. Ирүүлсэн мэдээлэл нь чин сэтгэлийн байх ёстой.

## Мэдээллийн хүртээмжийн бодлого (МХБ)

МХБ нь 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээс хойш ЕСБХБ мэдээллийг хэрхэн олон нийтэд ил тод болгох, өөрийн стратеги, бодлого болон үйл ажиллагааны талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэн сурталчлах чиглэлд оролцогч талуудтай хэрхэн зөвлөлдөх арга замуудыг тодорхойлсон байдаг. ЕСБХБ-ны вэб сайтаас ямар мэдээлэл авах боломжтойг мэдье гэвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#) хуудсанд зочилно уу.

Мэдээлэл авах тодорхой хүсэлтээ [ЕСБХБ-ны Лавлагааны маягт](#) ашиглан илгээх боломжтой.

## Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)

Хэрэв байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбоотой санал гомдлоо үйлчлүүлэгч болон Банкинд тавьж шийдвэрлүүлэх (жишээлбэл: үйлчлүүлэгчийн Төслийн түвшний гомдол барагдуулах механизмаар дамжуулж, эсвэл Банкны удирдлагатай шууд харилцах замаар) оролдлого, хүчин чармайлт нь амжилтгүй болвол, хувь хүн болон байгууллагууд санал гомдлоо ЕСБХБ-ны Төслийн хариуцлагын хараат бус механизм (ТХХБМ)-аар дамжуулан шийдвэрлүүлэхийг зорьж болно.

ТХХБМ нь Төсөлтэй холбоотой бусдад хор хохирол учруулсан (эсвэл учруулж болзошгүй) гэж үзэж буй асуудлуудыг хараат бусаар хянан шалгадаг. Энэхүү Механизмын зорилго нь байгаль орчин, нийгэм болон мэдээллийн ил тод байдалтай холбогдох асуудлуудыг шийдвэрлэх талаар Төслийн оролцогч талуудын хоорондох яриа хэлэлцээг дэмжих; Банк өөрийн [Байгаль орчин, нийгмийн бодлого](#), эсвэл [Мэдээллийн хүртээмжийн бодлого](#)-ын Төсөлд холбогдох заалтуудыг дагаж мөрдсөн эсэхийг тогтоох; мөн шаардлагатай тохиолдолд Банкны зүгээс эдгээр бодлогод үл нийцсэн зөрчлийг арилгах, түүний зэрэгцээ цаашид тийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэхэд оршино.

ТХХБМ болон түүний эрх үүргийн талаар илүү ихийг мэдэхийг хүсвэл [Төслийн хариуцлагын хараат бус механизмын вэб сайт](#), хянан шалгуулах хүсэлт тавих бол [Хүсэлт](#) хаягаар тус тус хандана уу. Эсвэл ТХХБМ-ын талаар, мөн санал хүсэлт хэрхэн тавих тухай чиглэл заавар, нэмэлт мэдээлэл авах бол [ipam@ebrd.com](mailto:ipam@ebrd.com) цахим шуудангаар хандаж болно.